

Харилцаа холбоо бол аюулгүй ажиллагааг сайжруулах түлхүүр. 2025 оны 2-р сар



Зураг 1.

Шугам хоолойн зураг ба мушгих зөв хүч

Эх сурвалж: CSB report No. 2021-01-I-TN

21м (70 фут) өндөр тоног төхөөрөмжийн тавцан дээр гүйцэтгэгч шугам хоолойн ажилтан хлорт устөрөгч (HCl) агуулсан дулаан солилцуур гаргах хоолойны жийргэвч боолтуудыг хэт их чангалсны улмаас хоолой хагарч, хортой хлорт устөрөгч (HCl) алдагдсан осол гарсан.

Тавцан дээр хоёр түншлэгч байгууллагын долоон ажилтан байсан. Алдагдсан хорт хийнээс зугтахын тулд гурван ажилтан бүтээцийн хажуу талын хоолойгоор доош буусан, гурвуулаа газар унасан. Нэг ажилтанд амь насанд аюултай гэмтэл учирсан, үлдсэн хоёр ажилтан мөн ноцтой гэмтэл авсан.

Компаниас шугам хоолойн багийн ахлахад ажлын даалгаврыг тайлбарлаж өгсөн. Мөн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн гарын авлагыг өгсөн ба үүнд фторопласт (PTFE) материалаар доторлосон шугам хоолойн боолтыг 54 жоуль (40 ft-lbs) хүчээр чангалахыг заасан байсан (Зураг 1). Гарын авлагад PTFE хоолойг дулаан солилцуур бал чулуун хошуутай холбогч боолтыг буюу доод боолтыг хэр зэрэг мушгих хүчээр чангалах тухай тусгагдаагүй байсан. Компаниас тухайн шугам хоолойн гүйцэтгэгчид дулаан солилцуурын зургийг өгчихсөн байсан бөгөөд үүнд 20 жоуль (15 ft-lbs) хүчээр чангалах шаардлагатайг заасан байсан. Шугам хоолойн ажилтнууд тухайн ажлыг гүйцэтгэхдээ уг зургийг биедээ авч яваагүй.

Ахлах ажилтан шугам хоолойн ажилтнуудыг дагуулан дулаан солилцуур руу очиж, ажлын даалгаврыг амаар шалгаж, чангалах хоолойн холболтуудыг зааж өгсөн. Ажилтнууд ажилдаа бэлдэхээр газар бууж, ахлах ажилтан ажлын талбайгаас явсан.

Өөр өөр чангалах хүч ашиглах шаардлагатайг тодорхой тайлбарлаагүйн улмаас ажиллаж байсан тоног төхөөрөмжийн жийргэвч боолтыг огцом чангалснаар тухайн тоног төхөөрөмж хагарч, хлорт устөрөгч (HCl) алдагдсан.

Та мэдэх үү?

- Алдааг багасгахад сайн боловсруулсан дүрэм журам, сургалтаас гадна шаардлагатай үед ажлын талбай дээр очиж, ажил эхлэхийн өмнө нарийн жижиг хэсгүүдийг баталгаажуулах алхам багтана.
- Хэн нэгэнд нөхцөл байдлыг бодитоор харуулах нь тухайн хүн ажлын даалгаврыг бодитоор харах, асуулт асуух, ажлаа эхлэхээс өмнө асуултынхаа хариултыг авах боломж олгодог.
- Бичгээр үйлдсэн зааварчилгаа нь ажил явагдах талбай руу авч явах боломжтой баримт бичиг болдог.
- Аман харилцаа холбоо нь хамгийн хурдан бөгөөд амархан хэлбэр боловч буруу ойлголцох магадлал өндөр.
- Тодорхой нэг бүлгийн ашигладаг өвөрмөц үгнүүдийг этгээд буюу мэргэжлийн хэллэг гэдэг. Тэдгээр үгс ажлын бүлгээс гадна хүмүүст өөр утгаар ойлгогдох боломжтой, жишээлбэл гүйцэтгэгч багийн гишүүдэд.

Та юу хийх ёстой вэ?

- Бүртгэлийн дэвтэр, бусад бүх төрлийн тэмдэглэлд мэдээллийг тодорхой бичиж оруулах. Тоног төхөөрөмжийн тодорхойлолт эсвэл дугаарыг ашиглаж, товчилсон үг, этгээд мэргэжлийн хэллэгээс зайлсхийх.
- Шугам хоолой салгах байршлууд, эсвэл хоолойн холболт зэрэг чухал асуудлууд, даалгавруудыг тухайн ажлыг гүйцэтгэх хүмүүст талбай дээр нь зааж харуулах
- Гэрээт ажилтнуудад ажил гүйцэтгэх газарт нь зөвшөөрөл олгох. Хийгдэх ажлыг хамтдаа хянахад нэмэлт цаг гаргаснаар цаг хугацаа хэмнэж, осол гарахаас зайлсхийх боломжтой.
- Радио станцаар харилцахдаа мэдээлэл өгсөн хүнийг давтаж, зөв ойлгосон эсэхээ баталгаажуулах.
- Дараагийн хийх алхамд итгэлгүй байвал хэн нэгнээс заавал асуугаарай. Бага зэрэг саатах нь ноцтой осол гаргаснаас хамаагүй дээр.

Чухал мэдээлэл, зааварчилгааг бичгээр боловсруулж, ноцтой эрсдэлтэй холбоотой асуудлыг дүрсээр тодорхой харуулах нь зүйтэй.